**“Хай Би Ойл” ХК-ийн 2019 оны**

**үйл ажиллагааны тайлан**

Нэр: **“Хай Би Ойл” ХК**
Хаяг: Улаанбаатар хот, СХД, 20-р хороо, Сонсголонгийн /18135/ 110 тоот
Утас: (+976) – 88119740

| | |
|---|---|
| Улсын бүртгэлийн мэдээлэл: | № 9010001063, |
| Регистрын дугаар | № 2615134 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл, |
| Үнэт цаасны тоо ширхэг: | 52,118,954 ширхэг |

***Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд: Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд:***

Өмнөх оны тосны үлдэгдэл түүхий эдийн нөөц 292’328 литр, боловсруулсан тосны нөөц /Мазут/ 2’729 литр байсан ба 2019 он гарснаас хойш тайлант хугацаанд “Хай Би Ойл” ХК нь нийт 1,045,263л буюу 180,594,375 төгрөгийн түүхий эдийг байгууллага болон хувь хүнээс цуглуулсан байна. Үүнээс 1,057,624л мазут боловсруулан авч 4 аж ахуйн нэгжид 834,957,000₮ /НӨАТ орсон үнэ/ төгрөгийн үнэ бүхий 955,132л мазутыг борлуулсан байна. Дээрх тоон үзүүлэлтүүдийн задаргааг харуулбал:

Түүхий эд материал:

| Нэр | Нэгж | 2018 оны үлдэгдэл | 2019 оны бүтэн жилээр |
|---|---|---|---|
| Түүхий эд буюу ажилласан масло | литр | 292’328 | 1,045,263 |
| **Нийт** | литр | **1,337,591** | |

Борлуулалт:

| № | Худалдан авсан байгууллагын нэр | Хэмжээ | НӨАТ орсон үнэ /төгрөг/ | |
|---|---|---|---|---|
| | | | Нэгж үнэ | Нийт үнэ |
| 1 | “МБИндустрал” ХХК | 198’000 л | 830 | 164’340’000 |
| 2 | “Наранбулаг хан” ХХК | 439,972 л | 900 | 395’974’800 |
| 3 | “Нефть проект” ХХК | 165’960 л | 820 /850/ | 138’562’200 |
| **4** | Дэвжих эрдэнэ” ХХК | 151,200л | 900 | 136’080’000 |
| **Бүгд дүн** | | **955’132 л** | | **834’957’000** |

***Гэрээ хэлцэлүүд болон томоохон худалдан авагчид:***

2019 оны тайлант хугацаанд түрээсийн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбогдолтой 3 гэрээ, ажил үйлчилгээ үзүүлэх 11 гэрээ, худалдах ба худалдан авахтай холбогдолтой 19 гэрээнүүдийг тус бүр байгуулсан байна.2018 онд хийгдсэн “Таван

Богд”ХХК, “Монгол Хьюндай Автомотив”ХХК, “М-Ойл Любрикэнтс”ХХК, “Сэ Бо Цэ” ХХК зэрэг ажилласан масло худалдан авах гэрээнүүд хугацаа нь дуусаагүй тул үргэлжлүүлэн хамтран ажиллаа.

2019 онд хийгдсэн гэрээнүүдийг жагсаавал:

| № | Гэрээ байгуулсан компани | Гэрээний агуулга | Эхлэх | Дуусах | Гэрээний үнэ |
|---|---|---|---|---|---|
| Түрээс, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой | | | | | |
| 1 | “ҮЦТХТ” ХХК | Үнэт цаасны хадгаламжийн төлбөр гүйцэтгэх гэрээ | 2019/04/12 | 2019/12/31 | 400,000₮ |
| 2 | ХХБанк | Үнэт цаасны төлбөр тооцооны дансны гэрээ | 2019/04/30 | --- | |
| 3 | “Юнистар Аудит” ХХК | Аудитын ажил гүйцэтгэх | 2019/01/28 | 2019/04/25 | 12’500’000₮ |
| Ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ | | | | | |
| 1 | “Ногоон титэм” ХХК | Үйлдвэрийн агаарын шинжилгээ хийх | 2019/05/27 | 2020/05/27 | 800’000₮ |
| 2 | СХД-ийн татвар болон Тээвэрлэлт Үйлчилгээний Төв | ХХҮХураамж, тээвэрлэх гэрээ | 2019/04/02 | 2020/04/02 | Нэг рейс бүр 60’000₮ |
| 3 | “ДАЗЛ” ХХК | Харуул хамгаалалтын ажил үйлчилгээ | 2019/03/01 | 2020/03/01 | 2,700,000₮ сар бүр төлөх |
| 4 | Иргэн Г.Хишигт | ЦТП, трансф.-ын засварын гэрээ | 2019/04/06 | 2019/04/08 | 4,890,050₮ |
| 5 | Иргэн Т.Алтансүх | Газар шорооны ажлын гэрээ | 2019/05/09 | 2019/05/09 | 500’000₮ |
| 6 | “Хөх Гүрэн Констракшин” ХХК | Агааржуулалт суурьлуулсан гэрээ | 2019/05/23 | 2019/06/07 | 600.000₮ |
| 7 | Эрдмийн шим ХХК | Галын дохиолол суурилуулсан | 2019/06/19 | 2019/06/21 | 1,834,140₮ |
| 8 | Иргэн Э. Мөнх-Од | Блокон хашаа, хаалганы засвар | 2019.09.18 | 2019.09.27 | 2,900,000₮ |
| 9 | Иргэн Р.Баянмөнх | Тээврийн гэрээ | 2019.12.11 | 2020.04.01 | 10,172,180₮ |
| 10 | Иргэн Ж.Батбаатар | Тээврийн гэрээ | 2019.08.13 | 2019.10.15 | 14,609,019₮ |
| 11 | Иргэн Г.Бямбадоо | Тос халаагч тогоо суурьлуулах ажил | 2018/11/30 | 2019/03/01 | |
| Худалдах, худалдан авах гэрээ | | | | | |
| 1 | “Наранбулаг хан”ХХК | Мазут худалдах | 2019/04/15 | 2020/04/15 | 225’000’000₮ |
| 2 | “Нефть Проект” ХХК | Мазут худалдах | 2019/05/06 | 2019/08/31 | 200 тонныг 164’000’000₮ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | “Эко Асфальт” ХХК | Мазут худалдах | 2019/05/14 | 2020/05/14 | 90’000’000₮ |
| 4 | “Монгол Битум Индустриал” ХХК | Мазут худалдах | 2019/05/08 | 2020/05/08 | 207’500’000₮ |
| 5 | “Дэвжих Эрдэнэ” ХХК | Мазут худалдах | 2019/07/08 | 2020.07.08 | 135’000’000₮ |
| 6 | “Таван богд” ХХК | Ажилласан масло худалдан авах | 2019.07.23 | 2020.07.23 | Газар дээрээс нь очиж авах |
| 7 | “Цайртминериал” ХХК | Ажилласан масло худалдан авах | 2019.08.16 | үргэлжлэх | Газар дээрээс нь очиж авах |
| 8 | Камминс монголиа Инвестмэнт ХХК | Ажилласан масло худалдан авах | 2019/07/30 | 2020/07/30 | Газар дээрээс нь очиж авах |
| 9 | “Дельта авто сервис” ХХК | Ажилласан масло худалдан авах | 2019/07/22 | 2020/07/22 | Газар дээрээс нь очиж авах |
| 10 | “М-Ойл Любрикэнтс” ХХК | Ажилласан масло худалдан авах | 2019.09.01 | 2020.09.01 | Газар дээрээс нь очиж авах |
| 11 | Си Ар Найнтээн Бюроюро Монголиа ХХК | Ажилласан масло худалдан авах | 2019.12.11 | 2020.12.11 | Газар дээрээс нь очиж авах |
| 12 | “Буд-Ундрам”ХХК | Ажилласан масло худалдан авах | 2019/04/08 | 2020/04/08 | Өөрийн унаагаар тээвэрлэж ирэх |
| 13 | “Сокобура” ХХК | Ажиллсаан масло худалдан авах | 2019/04/01 | 2020/04/01 | Өөрийн унаагаар тээвэрлэж ирэх |
| 14 | “НИК” ХХК | Ажилласан масло худалдан авах | 2019/05/08 | 2020/05/08 | Өөрийн унаагаар тээвэрлэж ирэх |
| 15 | “МСМ групп”ХХК | Ажилласан масло худалдан авах | 2019/01/01 | 2020/01/01 | Газар дээрээс нь очиж авах |
| 16 | Иргэн Ш.Энхболд | Ажилласан масло худалдан авах | 2019/04/01 | 2019/04/10 | Өөрийн унаагаар тээвэрлэж ирэх |
| 17 | Иргэн Р.Баянмөнх | Ажилласан масло худалдан авах | 2019/05/13 | 2019/09/30 | Өөрийн унаагаар тээвэрлэж ирэх |
| 18 | Иргэн Д.Лхагвасүрэн | Ажилласан масло худалдан авах | 2019/05/21 | 2019/09/30 | Өөрийн унаагаар тээвэрлэж ирэх |
| 19 | Иргэн Н.Уянга | Ажилласан масло худалдан авах | 2019/04/01 | 2019/04/10 | Өөрийн унаагаар тээвэрлэж ирэх |

***Тайлант хугацаанд хийгдсэн ажлууд:***

1. 2019.04.06-нд үйлдвэрийн хашаанд байрлах ЦТП цахилгааны дэд станцын трансформатор хэсгийн дээд таг болон тэлэгч резин жийрэгнүүдийг сольж, дотор талыг нь бүрэн цэвэрлэн, нам талын дотор шаазан солих байсан тул өндөр хүчдэлийн мэргэжилтэн цахилгаанчинтай засвар үйлчилгээний гэрээг хийж гэрээний дагуу засвар үйлчилгээ хийлгэж трансформаторын тосыг бүтэн солих,бүтэн будах зэрэг засварын үйлчилгээнд нийт 4,890,050₮ төгрөгийн зардал гарсан.




26-48 УБ












2. 2019.03.27 Оффисын үүд болон үйлдвэрийн хойд хаалга орчмыг хэсэгчлэн тэгшлэн бетондож цементлэв.



Бетондож буй ажлын явц



Бетондсоны дараах байдал

3. Тайлант хугацаанд ажилчдын унаа машин (Prado, Starex) болон тосны цистернүүдэд (Kia Rhino) ээлжит урсгал засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл, ЕС

зөвшөөрөл, хот дотор явах түр зөвшөөрөл (хагас жилээр буюу 2019.12.31-г дуустал), тээврийн улсын үзлэг, оношилгоо, даатгалд зэрэгт хамруулсан.












4. 2019.04.08 2018 онд үйлдвэрийн тос халаагч тогоонд гэмтэл гарч шинээр солих шаардлагатай болсон тул иргэн Г.Бямбадоотой гэрээ хийж халаагч тогоог гэрээнд заасан хугацааны дагуу суурилуулж, үйлдвэрийн үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож хүлээн авсан болно.



Тос халаагч өмнөх тогооны зураг



Шинэ тос халаагч тогооны зураг




Тос халаагч тогоогоо суурилуулж, цахилгаантай холболт хийж бэлэн болгов.

6. 2019.04.18 Аюултай хог хаягдал болох техникийн ажилласан тос хадгалах агуулахын суурийг цэвэрлэж бетондох бэлтгэл ажлыг хийсэн.



Агуулахын суурийг цэвэрлэж тэгшлэж байгаа нь

7. 2019.05.07 БОАЖЯамнаас зохион байгуулсан “Хог хаягдлын менежмент үндэсний форум“ чуулганд оролцож аюултай хог хаягдал болох техникийн ашигласан тосыг дахин боловсруулдаг байгаль орчинд ээлтэй үйлдвэрийн тоног төхөөрөмж болон үйлдвэрийн үйл ажиллагаагаа , боловсруулсан бүтээгдэхүүнээ танилцуулж оролцов. Энэ форум чуулганд орон нутгийн ААН, компаниуд, нийслэл дүүргүүдийн төлөөлөл болон байгаль орчин хариуцсан мэргэжилтэнүүд оролцож манай компанитай хамтарч ажиллахаар санал бодлоо солилцсон.










8. Үйлдвэрийн галын аюулгүй байдлыг хангах үүднээс галын хор , гал унтраах тоноглол болон , төмөр сараа, элс зэргийг дахин будаж нэмж байршуулсан болно.















9. 2019.05.09 Иргэн Т.Алтансүхтэй газар шорооны ажлын гэрээ хийж тосны агуулах савнуудын доод болон хажуу ханыг тэгшилж бетондоход бэлэн болгох мөн оффисын үүдний овгор шороог тэгшилж засан авто машины зогсоол болгон бетондсон.







Шороог тэгшилж буй байдал










Бетондож авто зогсоол болгов.

10. 2019.05.20 Үйлдвэрийн барилгад агааржуулалтын хоолойг “Хөх гүрэн Констракшин” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ хийж суурьлуулж бэлэн болгосон.



Агааржуулалтын хоолойг суурилуулж буй явц

11. 2019.05.22 Үйлдвэрийн хашаан дотор цэвэр болон бохирдсон хэсгийн хөрсний шинжилгээ, усны шинжилгээ, үйлдвэрийн дотор болон гадна орчны агаарын шинжилгээнүүдийг хийлгэсэн.

"НОГООН ТИТЭМ" ХХК
Хан Уул дүүрэг, 3-р хороо,
Сан-Констракшн ХХК байр 222 тоот
Утас: 70005432; 88099064

НОГООН ТИТЭМ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

**Сорилтын дүнгийн хуудас**

| Байршил-2: Үйлдвэрийн гадна | | | | Огноо: 2019-05-28 |
|---|---|---|---|---|
| Сорьц | T: 19.8°C | P:1014 гПа | N: ——— | E: ——— |
| | Эхэлсэн цаг: | 10:08 | Дууссан цаг: | 10:48 |

**Органик биш нэгдэл**

| № | Тодорхойлсон нэгдэл | Сорилтын аргын Стандарт | Илрүүлах хязгаар | Хэмжээ |
|---|---|---|---|---|
| | | | мкг/м$^3$ | |
| 1 | Азотын давхар исэл, $NO_2$ | MNS ISO 6768:2005 | 3-2000 | **52.23** |
| 2 | Хүхэрлэг хий, $SO_2$ | ISO 6767:1990 | 20-500000 | **<20** |

**Органик нэгдэл**

| № | Тодорхойлсон нэгдэл | Сорилтын аргын Стандарт | Илрүүлах хязгаар | Хэмжээ |
|---|---|---|---|---|
| | | | мкг | мкг/м$^3$ |
| 1 | Формальдегид | NIOSH 3500 | >0.5 | **11.38** |

**Дэгдэмхий органик нэгдэл**

**Сорьц: VOC/226**

| № | Тодорхойлсон нэгдэл | Сорилтын аргын Стандарт | Илрэх хугацаа | Илрүүлах хязгаар | Хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| | | | мин | мг | мг/м$^3$ |
| 1 | Бензол | NIOSH 1501 | 3.16 | 0.004-0.35 | **<0.004** |
| 2 | Толуол | | 5.85 | 0.024-4.51 | **<0.024** |
| 3 | Этилбензол | | 12.13 | 0.045-8.67 | **<0.045** |
| 4 | п.м-Ксилол | | 13.06 | 0.043-0.861 | **<0.043** |
| 5 | о-Ксилол | | 15.63 | 0.044-10.4 | **<0.044** |

Тайлбар:
- буюу хасах тэмдэглэгээ нь сорилт хийгдээгүй болно.
* буюу од тэмдэглэгээ нь итгэмжлэлийн хүрээнд ороогүй үзүүлэлт болно.










12. 2019.05.20 Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөгөө хийж батлуулсан.

"ХАЙ БИ ХК-НИЙ "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө"

УЛААНБААТАР ХОТ

БАТЛАВ:

"ХАЙ БИ ОЙЛ" ХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ш.АМАР-ОТГОН

# ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Боловсруулсан : 2019 оны 5 сарын 20 өдөр
Тодотгосон : 20 . . . оны . . . сарын . . . өдөр
20 . . . оны . . . сарын . . . өдөр

БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ: СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ, 20-Р ХОРОО, СОНСГОЛОН 18135 -110 ТООТ

ХЯНАСАН:
ГАМШГААС ХАМГААЛАХ ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ОРЛОГЧ,
ТӨЛӨВЛӨЛТ БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
АХЛАХ БАЙЦААГЧ, ХОШУУЧ Т.ДӨЛ

БОЛОВСРУУЛСАН: "ХАЙ БИ ОЙЛ" ХК
ҮЙЛДВЭРИЙН МЕНЕЖЕР Ш.АМАРСАЙХАН

Ш. Амарсайхан.

УЛААНБААТАР ХОТ

2019 ОН

13.2019.05.24 Тус компани дээр БОАЖЯам, ЗТХЯам, МХЕГазар зэрэг газруудын хамтарсан хяналт шалгалт хийгдсэн. Энэ хяналт шалгалтаар тус компани нь үйлдвэрийн тоног төхөөрөмж, үйлдвэр , хашаан доторхи эмх цэгц, хөрсний бохирдол зэргээр сайн гэсэн үнэлгээ авсан болович "Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах" үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл байхгүй тул яаралтай авах шаардлагатай гэж үзэн дахин боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг түр хугацаагаар

зогсоосон болно. Иймд тус компани нь үүнтэй холбогдуулж нэлээдгүй ажлуудыг хийж гүйцэтгэн бүрдүүлэх материалуудыг бэлэн болгож БОАЖЯаманд хүргүүлснээр 2019.06.25-нд хурлаар орж“Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах “ үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авч амжилттай ажиллаж байна.



АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ,
ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 0000005 Огноо: 2019.07.30

Хавсралт 1 -д заасан нөхцлийн дагуу аюултай хог хаягдал Авто тээврээс гарч буй ашигласан тосыг тээвэрлэх, цуглуулах хадгалах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 9010001063 улсын бүртгэлийн дугаартай 2615134 регистрийн дугаартай "Хай Би Ойл " ХК -д 2019 оны 07 дугаар сарын 26 -ны өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 26 -ны өдөр 1 жилийн хугацаагаар олгов.

**Үйл ажиллагаа эрхлэх талаарх мэдээлэл:**

Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн дугаар 00004

Аж ахуйн нэгж/иргэний хаяг: Улаанбаатар аймаг, хот Сонгинохайрхан сум, дүүргийн 20-р баг, хорооны Үйлдвэрлэл нүүрсний газрын урд

Зөвшөөрөл олгосон үйл ажиллагаа явуулах газрын байршил: Улаанбаатар аймаг, хот Сонгинохайрхан сум, дүүргийн 20-р баг, хорооны Үйлдвэрлэл нүүрсний газрын урд

**Хавсралт нь энэхүү зөвшөөрлийн салшгүй нэг хэсэг болно.**

**Зөвшөөрөл олгосон:**

БОАЖ-ын сайд (байгууллагын нэр, албан тушаал) (гарын үсэг, тамга) Н.Цэрэнбат (овог нэр)



2019 оны 07 сарын 26 өдрийн
00004 зөвшөөрлийн
1 хавсралт

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019.07.26-ны өдрийн А/378 тоот тушаалыг үндэслэн олгов.

БОАЖ-ын сайд (байгууллагын нэр, албан тушаал) (гарын үсэг, тамга) Н.Цэрэнбат (овог нэр)

**САНАМЖ:**

Тус хамнаас олгосон энэхүү гэрчилгээг зориулалтын бусаар ашигласан, үйл ажиллагаандаа ноцтой алдаа дутагдал гаргасан, худалдан борлуулсан, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн бол хүчингүй болгох үндэслэл болно.

14. Гүний худгаас үйлдвэр хүртлэх ус дамжих ган шугам хоолой нь газраар байсныг дээгүүр блокон хашаагаа дагуулан ган хоолойгоо суурилуулж үйлдвэртэйгээ холбон өөрчилж угсралт суурилуулалт хийсэн.










15. Тос хадгалах агуулахуудын суурийг 3,840,000₮ -өөр бетон зуурмаг худалдан авч үйлдвэрийн ажилчид нь бетон зуурмагаа тэгшилж бетондох ажлыг хийлээ.



Агуулахуудын суурийн шороог тэгшилж бетондов.

16. Үйлдвэрийн блокон хашааны баруун талыг 3 үе давхарлан өрж өндөргөсөн ба хашааны хаалгыг шинэчилж хийсэн.








17. Үйлдвэрийн хажуу хашаанд “Таван толгой” ХХК-ний сайжруулсан шахмал түлшний үйлдвэр ажиллаж эхэлсэнээс хойш хашааны хаалганы орчим зогсох автомашинуудын замбараагүй зогсолтуудыг хянах үүднээс камер нэмж суурьлуулж, тэмдэг тэмдэглэгээгээ сайжруулж тавьсан.





*2019 оны жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд:*

2019 онд нийт 760’366’600₮ төгрөгийн борлуулалтын орлоготой, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 415’669’300₮, ерөнхий удирдлагын зардал 268,956,500₮ бусад зардал хасагдаад 128,467,000 төгрөгийн цэвэр ашигтай ажиллаа.Үүнээс цалин хөлсний зардалд 163,834,213₮, нийгмийн даатгалын шимтгэлд 23,363,240₮, ХХОАТ-т 15,618,282₮, НӨАТ-т 78,978,045₮, газар үл хөдлөх хөрөнгийн албан татварт 3,259,347₮, түүхий эд, материалын зардалд 184,148,375₮, өмнөх оны дансны өглөгт 81,875,396₮-ийн зардлууд гарсан байна.

*2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан:*

# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ХАЙ БИ ОЙЛ ХХК
(Аж ахуйн нэгжийн нэр)

2020 оны 02 сарын 09 өдөр
(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | БАЛАНСЫН ЗҮЙЛ | Үлдэгдэл | |
|---|---|---|---|
| | | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12 сарын 31 |
| А | Б | 1 | 2 |
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | - | - |
| 1.1.1 | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 51,945,419.62 | 252,039,809.91 |
| 1.1.2 | Дансны авлага | 1,500,438,003.91 | 1,464,897,503.00 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 13,982,552.65 | 3,491,190.86 |
| 1.1.4 | Бусад авлага | 483,890,994.60 | 492,944,178.30 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | | |
| 1.1.6 | Бараа материал | 123,568,284.77 | 134,310,757.74 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 39,205,502.86 | 20,610,324.63 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | | |
| 1.1.10 | | | |
| **1.1.20** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **2,213,030,758.41** | **2,368,293,764.44** |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 1,187,285,930.40 | 1,042,595,730.08 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | | - |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | | |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 1,636,952,132.00 | 1,691,233,612.00 |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | | |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | | |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | | |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| 1.2.9 | | | |
| | | | |
| | | | |
| **1.2.20** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **2,824,238,062.40** | **2,733,829,342.08** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,037,268,820.81** | **5,102,123,106.52** |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ | | |
| 2.1 | ӨР ТӨЛБӨР | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 302,633,872.28 | 228,287,741.85 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 129,136,875.43 | 129,136,875.43 |
| 2.1.1.3 | Татварын өр | 2,558,484.28 | 6,900,599.55 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | - | - |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | - | - |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | | |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | | - |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | - | - |
| 2.1.1.9 | Нөөц/өр төлбөр/ | | |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 117,809,055.00 | 117,436,140.00 |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус | | |
| 2.1.1.12 | | | |
| **2.1.1.20** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **552,138,286.99** | **481,761,356.83** |

| | | | |
|---|---|---|---|
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | | |
| 2.1.2.2 | Нөөц/өр төлбөр/ | | |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | 71,449,317.58 | 78,003,580.38 |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.5 | | | |
| | | | |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **71,449,317.58** | **78,003,580.38** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **623,587,604.57** | **559,764,937.21** |
| 2.3 | Эздийн өмч | | |
| 2.3.1 | Өмч : - төрийн | | |
| 2.3.2 | -хувийн | 5,211,895,400.00 | 5,211,895,400.00 |
| 2.3.3 | -хувьцаат | | |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | | |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | 4,592,503,138.14 | 4,592,503,138.14 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | | - |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | (5,390,717,321.90) | (5,262,040,368.83) |
| 2.3.10 | | | |
| **2.3.11** | **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **4,413,681,216.24** | **4,542,358,169.31** |
| **2.4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **5,037,268,820.81** | **5,102,123,106.52** |

Захирал /Ш.Амар-Отгон /

Ерөнхий нягтлан бодогч /Б.Бадамханд/

## ОРЛОГЫН ТАЙЛАН

ХАЙ БИ ОЙЛ ХХК
(Аж ахуйн нэгжийн нэр)

2020 оны 02 сарын 09 өдөр
(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 950,149,642.90 | 760,366,545.50 |
| 2 | Борлуулсан бүтээгдхүүний өртөг | 629,251,222.82 | 415,669,385.81 |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | 320,898,420.08 | 344,697,159.69 |
| 4 | Түрээсийн орлого | | |
| 5 | Хүүгийн орлого | 1,719,461.78 | 2,107,353.32 |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | |
| 8 | Бусад орлого | 180,000.50 | 381,020.73 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | | |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 282,087,814.78 | 268,956,468.06 |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | (4,207,520.96) | - |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 156,114,971.65 | 65,542,628.04 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | (706,403.18) |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн үүссэн олз (гарз) | | |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | | |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 192,617,518.27 | 143,065,290.54 |
| 19 | Орлогын татварын зардал-Орлогын татвар | 3,924,070.42 | 8,044,074.67 |
| | Хойшлогдсон орлогын албан татварын зардал | 15,611,497.16 | 6,554,262.80 |
| 20 | Татварын дараах ашиг алдагдал | 173,081,950.69 | 128,466,953.07 |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал | | |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал | 173,081,950.69 | 128,466,953.07 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |
| | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| | Бусад олз (гарз) | | |
| **24** | **Орлогын нийт дүн** | **173,081,950.69** | **128,466,953.07** |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | | |

Дарга(Захирал) /Ш.Амар-Отгон /

Нягтлан бодогч /Б.Бадамханд/

5

## ***5. 2019.04.26 ”Хай Би Ойл” ХК-ийн ХЭХ-ын хурлын талаар:***

1) **2019 оны 04 сарын 26**-ны өдрийн Баасан гаригийн 10:00 цагт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг “Баянгол” зочид буудлын хурлын танхимд зарлан хуралдуулж дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

a) Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

b) 2018 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;

c) Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

d) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийн сонгох;

e) Компанийн ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай

f) ТУЗ-с гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах;

Дээрх хуралдааны тогтоол шийдвэрүүдийг Монголын Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн бирж, түүний вэб хуудаснуудад тухай бүр өгч хууль дүрэм, журмын дагуу байршуулан ажилласан.

## ***Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:***

Компани нь нийт 52’118’954 ширхэг хувьцаатай ба 381 хувьцаа эзэмшигчидтэй байна. Үүнээс нийт хувьцааны 5% буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | Нийт хувьцааны | |
|---|---|---|---|
| | | Тоо ширхэг | Хувь |
| 1 | “БиДиСЕК” ХК | 7.813.699 | 14.99% |
| 2 | Firebird Global Master Holdings-2 S.A.R.L | 6’779’913 | 13.01% |
| 3 | Firebird Mongol Holdings A S.A.R.L | 9’829’928 | 18.86% |
| 4 | “Нью альфа” ХХК | 17’327’908 | 33.25% |
| 5 | “Монгол алтан минт” ХХК | 4’167’934 | 8.00% |
| **Дүн** | | | **88.11%** |

/ ҮЦТХТ-өөс 2019.04.04-ний өдрөөр тасалбар болгон авсан мэдээ. /

## ***Удирдлагын талаархи мэдээлэл:***

**2019.04.26** -ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Батбаатар, Б.Лхагвадорж, А.Батбаяр, С.Ариунбат, Б.Мянганбаяр, Ж.Эрдэмбилэг нар, хараат бус гишүүдээр А.Харцага, Т.Тамир, Ц.Батбаяр нар сонгогдож, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Батбаатар, Гүйцэтгэх захирлаар Ш.Амар-отгон, ТУЗ-ийн нарийн бичгээр Н.Батнайрамдал нар сонгогдож ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

## **ТУЗ-ийн хурлын талаар:**

Тайлант хугацаанд “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ нь 5 удаа санал асуулгаар хуралдсан байна. Үүнд:

1. 2019 оны 01 сарын 28-ны өдөр ТУЗ-ийн нийт гишүүдэд саналын хуудас хүргүүлж a. 2018 оны үйл ажиллагаанаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хувиарлах эсэх, b. “Юнистар аудит” ХХК-аар “Хай Би Ойл” ХК-ийн жилийн

эцсийн санхүүгийн тайлан балансад аудит хийлгэх тухай асуудлуудыг хэлэлцээд тус компаиар аудит хийлгэх, гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захиралд даалгаж мөн 2018 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хувиарлахгүй байх шийдвэрийг тус тус гаргасан.

2. 2019 оны 03 сарын 15-ны өдөр саналын хуудсаар “Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай асуудлыг хэлэлцэж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралыг 2019 оны 04 сарын 26-ны өдөр хуралдуулхаар шийдвэрлэсэн.
3. 2019 оны 03 сарын 28-ний өдөр саналын хуудсаар Өрөндөө хувьцаа шилжүүлэн авах тухай асуудлыг хэлэлцэж “Хай Би Ойл” ХК болон “Шарын гол” ХК нарын хооронд 2014 оны 07 сарын 30-ны өдөр, 2015 оны 07 сарын 01-ны өдөр тус тус байгуулсан зээлийн гэрээнүүдийн дагуу авах авлагыг “Шарын гол” ХК-ийн хувьцаагаар сольж, хувьцаа авахыг зөвшөөрч шийдвэрлэсн.
4. 2019 оны 05 сарын 24-ний өдөр саналын хуудсаар хуралдаж, 2019 оны 04 сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралаар томилогдсон ТУЗ-ын гишүүдээс ТУЗ-ын дарга, ТУЗ дэргэдэх хороодын бүрэлдэхүүнүүдийг болон ТУЗ-нарийн бичгийн даргыг тус тус томилж, “Хай Би Ойл” ХК-ийн 137 ширхэг хөрөнгийг санхүүгийн тайлангийн бүртгэлээс хасч шийдвэрлэсэн болно.